

Судалгаанд оролцох зөвшөөрөл

Таныг судалгаанд оролцохыг урьж байна. Таныг зөвшөөрөхөөс өмнө судалгааны хураангуй мэдээллийг танд өгөх ёстой. Та судалгаанд оролцохыг хүсэж болох эсвэл оролцохыг хүсэхгүй байж болох шалтгааныг ойлгоход танд туслах чухал мэдээллийг үүнд оруулсан байх ёстой.

Та зөвшөөрөхийн өмнө судлаач танд дараах зүйлийн талаар хэлэх ёстой:

- (i) судалгааны зорилго, ажилбар, үргэлжлэх хугацаа;
- (ii) туршилтын чанартай аливаа ажилбар;
- (iii) судалгаанаас гарч болзошгүй аливаа эрсдэл, зовиур, ашиг тус;
- (iv) үр дүнтэй байж болох бусад ажилбар эсвэл эмчилгээ;
- (v) нүүцыг хэрхэн хадгалах;
- (vi) асуулт, санал гомдол, гэмтэл байвал хэнтэй холбоо барих.

Шаардлагатай тохиолдолд судлаач мөн дараах зүйлийг танд хэлэх ёстой:

- (i) гэмтсэн тохиолдолд авах боломжтой нөхөн олговор эсвэл эмчилгээ;
- (ii) урьдчилан тооцоолох боломжгүй эрсдэл гарах эсэх;
- (iii) судлаач таны оролцохыг зогсоож болзошгүй нөхцөл байдал;
- (iv) танаас гарах аливаа нэмэлт зардал;
- (v) та оролцохоо зогсоохоор шийдвэл юу болох вэ;
- (vi) таны оролцох хүсэл эрмэлзэлд нөлөөлж болзошгүй шинэ нээлтийн талаар танд хэзээ мэдэгдэх;
- (vii) судалгаанд хэчнээн хүн хамрагдах;
- (viii) судалгаанд таны эрүүл мэндийн мэдээллийг ашиглахыг та хэрхэн зөвшөөрөх хэрэгтэй.

Та энэ судалгаанд сайн дураар оролцох бөгөөд хэрэв та оролцохоос татгалзвал эсвэл зогсоохоор шийдвэл таныг шийтгэхгүй, мөн та хөнгөлөлт тэтгэмж алдахгүй. Энэхүү баримт бичигт гарын үсэг зурна гэдэг нь судалгаа, мөн дээр дурдсан мэдээллийг танд амаар тайлбарласан бөгөөд та сайн дураараа оролцохыг зөвшөөрч байна гэсэн үг юм. Хэрэв та оролцохыг зөвшөөрвөл энэ баримт бичгийн гарын үсэг зурсан хуулбар, судалгааны англи хэл дээрх хураангуйг танд өгөх ёстой.

Асуулт байна уу?

Хэрэв танд энэ судалгааны талаар асуулт, санал гомдол, бэртэл гэмтэл, санаа зовж буй зүйл байвал судалгааны хураангуй дээр бичсэн утасны дугаарыг ашиглан судлаачтай холбоо барьж болно. Х эрэв судалгааны оролцогчийн хувьд таны эрхийн талаар асуулт байвал, эсвэл судлаачтай ярилцах боломжгүй гэж үзсэн асуулт, санал гомдол эсвэл асуудал байвал судалгааны хураангуй дээр бичсэн утасны дугаар эсвэл э-мэйл хаягаар Байгууллагын хяналтын зөвлөлийн албатай холбоо барина уу.

Оролцогчийн нэр

Оролцогчийн гарын үсэг

Огноо

Энэхүү судалгаанд оролцох зөвшөөрөл авах үед миний бие хэлмэрчээр байлцсан гэдгээ би баталж байна. Оролцогчийн хэл ба англи хэлний хооронд хэлмэрчлэх зохих мэдлэг, шаардлагатай ур чадвартай гэдгээ би баталж байна. Энэ маягтад гарын үсэг зурснаараа зөвшөөрөл авч буй судлаач, оролцогч хоёрын хоорондоо харилцахад нь бүрэн дүүрэн хэлмэрчилсэн болохоо би баталж байна.

Хэлмэрчийн нэр

Хэлмэрчийн гарын үсэг

Огноо